



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/278

Булган сум

Ой, хээрийн гал түймрийн эрсдэлээс
урьдчилан сэргийлэх байнгын хяналтын цэг
ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.2, 32.1.3, 32.1.7, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7, 17.2.20 дахь заалт, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх журам”, Улсын онцгой комиссын даргын 2026 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний удирдамж” 01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын онцгой комиссын 2026 оны “Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний тухай” 01 албан даалгаврын дагуу аймгийн хэмжээнд ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй сумдын нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймрийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх байнгын хяналтын цэгийг 2026 оны 04 дугаар сарын 17-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд ажиллуулсугай.

2. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх байнгын хяналтын цэгийн байршил, зөөврийн сууц, ажиллах хүн хүч, техник, баримт бичиг, заавар зөвлөмжийг бэлтгэн ажиллуулахыг Хангал сумын Засаг дарга (Ж.Батдорж), Сэлэнгэ сумын Засаг дарга (А.Ганбагана), Тэшиг сумын Засаг дарга (Б.Гансүх), Хутаг-Өндөр сумын Засаг дарга (Ж.Ууганбаяр), Бугат сумын Засаг дарга (Х.Ууганбаяр), Орхон сумын Засаг дарга (Х.Ундрахбаяр) нарт тус тус даалгасугай.

3. Байнгын хяналтын цэгийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг Гамшгаас хамгаалах тухай хууль, Ойн тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу холбогдох зардлаас шийдвэрлэж ажиллахыг дээрх сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Н.Хишигдорж), Байгаль орчны газар (А.Гантөмөр), Цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БҮРЭВ-ОЧИР



6326010300

Сугар Ажил 2026 өдөр бүр Doc:2026/Захирамж